



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Чандмань Баянхонгор ХК-ны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2021/2/СТА-ОНӨААН**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833      Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор:                      Б.Нарангэрэл Утас: 99009293      Цахим хаяг: <a href="mailto:Narangerelb@audit.gov.mn">Narangerelb@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	10
3.4. Материаллаг байдал.....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	10
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа.....	14
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.10. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР ХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХБАТ  
ТАНАА

2021.03.15 № 2/183

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Чандмань Баянхонгор ХК-ны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны бизнес төлөвлөгөөнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 70 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага**

2021 А4 ТООТ

• 005020248

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 1-р сарын 01	2020 оны 12 дугаар сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	140,429,260.56	11,550,090.82
1.1.2	Дансны авлага	25,131,186.43	138,265,099.77
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		7,602,980.94
1.1.4	Бусад авлага	35,204,107.98	34,053,339.94
1.1.6	Бараа материал	115,296,403.99	130,664,548.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.01	0.01
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>316,060,958.97</b>	<b>322,136,059.85</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,013,444,743.48	6,666,013,746.53
1.2.2	Биет бус хөрөнгө	23,777,383.66	21,958,836.94
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,037,222,127.14</b>	<b>6,687,972,583.47</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,353,283,086.11</b>	<b>7,010,108,643.32</b>
2.1.1.1	Дансны өглөг	185,739,444.68	62,305,551.96
2.1.1.3	Татварын өр	123,992,429.79	120,958,921.61
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.01	0.01
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>309,731,874.48</b>	<b>183,264,473.58</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	161,910,509.13	135,676,610.77
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>161,910,509.13</b>	<b>135,676,610.77</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>471,642,383.61</b>	<b>318,941,084.35</b>
2.3.1	Өмч:-төрийн	313,835,027.38	313,835,027.38
2.3.2	хувийн	78,458,800.00	78,458,800.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	595,487,073.82	595,487,073.82
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,411,286,311.10	5,328,308,403.68
2.3.9	Хуримтлагдсан ашиг	482,573,490.20	375,078,254.09
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>2,881,640,702.50</b>	<b>6,691,167,558.97</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,353,283,086.11</b>	<b>7,010,108,643.32</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,676,260,165.38	1,754,415,079.28
2	Борлуулалтын өртөг	1,531,112,722.04	1,787,387,333.99
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	145,147,443.34	- 32,972,254.71
5	Хүүний орлого	1,288,336.28	1,080,415.20
8	Бусад орлого	155,005,410.22	92,838,927.07
10	Ерөнхий ба удирдлагын зардал	53,356,242.71	68,918,286.30
12	Бусад зардал	20,309,591.22	27,175,042.11
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		- 45,264,696.82
17	Бусад ашиг ( алдагдал)	- 74,613,618.22	- 52,805,574.78
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	153,161,737.69	- 133,216,512.45
19	Орлогын татварын зардал	15,316,174.53	
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	137,845,563.16	- 133,216,512.45
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	137,845,563.16	- 133,216,512.45
24	<b>Орлогын нийт дүн</b>	137,845,563.16	- 133,216,512.45

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дд	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	1,201,106,611.10	344,589,427.49	2,533,476,939.79
3	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	1,201,106,611.10	344,589,427.49	2,533,476,939.79
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				137,984,062.72	137,984,062.72
5	Бусад дэлгэрэнгүй орлого			210,179,700.00		210,179,700.00
9	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	1,411,286,311.10	482,573,490.21	2,881,640,702.51
11	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	1,411,286,311.10	482,573,490.20	2,881,640,702.51
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-107,495,236.12	-107,495,236.12
13	Бусад дэлгэрэнгүй орлого			3,917,022,092.58		3,917,022,092.58
17	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	595,487,073.82	5,328,308,403.68	375,078,254.09	6,691,167,558.97

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,790,061,835.96	1,800,310,093.60
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,767,436,471.97	1,776,361,279.24
1.1.4	Буцаан авсан албан татвар	291,263.63	- 286,918.18
1.1.6	Бусад мөнгөн орлого	22,916,627.62	24,235,732.54
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,636,707,486.24	1,903,635,780.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	483,775,633.89	593,121,999.56
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	185,725,444.57	207,047,720.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	44,806,750.87	334,319,059.01
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	170,710,114.19	202,551,054.30
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	131,155,600.00	97,716,775.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	19,330,499.64	18,224,396.62
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	121,518,579.56	207,773,466.87
1.2.9	Бусад мөнгөн зарлага	479,684,863.52	242,881,307.92
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	153,354,349.72	- 103,325,686.63
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,288,336.28	1,080,415.20

2.1.5	Хүлээн авсан хүүний орлого	1,288,336.28	1,080,415.20
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,899,545.49	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,899,545.49	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 7,611,209.21	1,080,415.20
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,584,518.87	26,633,898.36
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	23,484,518.87	26,233,898.36
3.2.5	Бусад зарлага	100,000.00	400,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 23,584,518.87	- 26,633,898.36
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	122,158,621.64	- 128,879,169.79
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,270,638.92	140,429,260.56
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	140,429,260.56	11,550,090.82

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Хэмжиг х нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Цэвэр усан хангамж	төг/л	565,207,140.0	572,009,500.0	595,073,500.0	- 23,064,000.0	104.0
УТБ	төг/л	80,216,982.0	77,942,700.0	101,133,500.0	- 23,190,800.0	129.8
Ариутгах татуурга	төг/л	343,025,813.0	347,700,600.0	361,854,600.0	- 14,154,000.0	104.1
Суурь хураамж	тогтмо л	93,391,881.0	93,391,900.0	102,125,400.0	- 8,733,500.0	109.4
Дулаан хангамж	м3	570,423,761.0	600,341,800.0	581,639,800.0	18,702,000.0	96.9
<b>Дүн</b>		<b>1,652,265,577.0</b>	<b>1,691,386,800.0</b>	<b>1,741,826,800.0</b>	<b>- 50,440,300.0</b>	
Шуурхай засвар үйлчилгээ		23,994,588.0	25,000,000.0	13,917,100.0	11,082,900.0	55.7
Төндөрийн орлого		119,583,382.0	268,000,000.0	66,204,200.0	201,795,800.0	24.7
Бусад орлого		37,043,966.0	7,000,000.0	26,386,300.0	- 19,386,300.0	376.9
<b>Дүн</b>		<b>180,621,936.0</b>	<b>300,000,000.0</b>	<b>106,507,600.0</b>	<b>193,492,400.0</b>	<b>35.5</b>
<b>Нийт борлуулалтын орлого</b>		<b>1,832,887,513.0</b>	<b>1,991,386,800.0</b>	<b>1,848,334,400.0</b>	<b>143,052,100.0</b>	<b>92.8</b>
<b>Цалин түүнтэй адилтгах зардал</b>		<b>794,183,222.47</b>	<b>985,746,840.0</b>	<b>914,467,100.0</b>	<b>71,279,740.0</b>	<b>92.8</b>
Цалин		655,126,716.5	837,748,930.0	785,608,300.0	52,140,630.0	93.8
НДШ-Ажил олгогч		94,217,306.0	128,761,870.0	115,865,000.0	12,896,870.0	90.0
ТУЗ-цалин		12,960,000.0	16,800,000.0	11,450,000.0	5,350,000.0	68.2
ТУЗ-НДШ		1,879,200.0	2,436,000.0	1,543,800.0	892,200.0	63.4
<b>Нийгэмийн хэмжээлэл, ажилчидтай холбоотой зардал</b>		<b>95,955,134.48</b>	<b>131,045,080.0</b>	<b>84,484,800.0</b>	<b>46,560,190.0</b>	<b>64.5</b>
Нэг удаагийн буцалтгүй тусламж		8,743,254.6	3,500,000.0	4,200,000.0	- 700,000.0	120.0
Тэтгэмж		5,250,000.0	25,430,000.0	23,548,600.0	1,881,400.0	92.6
Шагнал урамшууллын зардал		10,988,891.2	10,900,000.0	3,658,600.0	7,241,400.0	33.6
Баяр ёслол-ажилчдын нийгмийн арга хэмжээнд		34,337,783.4	42,370,000.0	27,900,190.0	14,469,810.0	65.8
Сургалт		15,726,495.0	20,000,000.0	2,083,800.0	17,916,200.0	10.4
Албан томилолтын зардал		6,730,000.0	8,000,000.0	3,189,900.0	4,810,100.0	39.9
Ахмадын зардал		3,316,106.0	3,000,000.0	3,510,000.0	- 510,000.0	117.0
Ажилчдын хоолны зардал		10,882,606.3	17,845,080.0	16,393,800.0	1,451,280.0	91.9
<b>Татвар, төлбөр хураамж, даатгал</b>		<b>113,492,430.28</b>	<b>54,536,800.0</b>	<b>74,898,300.0</b>	<b>- 20,361,500.0</b>	<b>137.3</b>
Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар		1,692,633.50	2,433,000.0	1,786,200.0	646,800.0	73.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр		10,742,278.48	5,000,000.0	7,590,600.0	- 2,590,600.0	151.8
Газрын төлбөр		5,797,196.00	2,497,200.0	3,977,500.0	- 1,480,300.0	159.3
Үл хөдлөх хөрөнгийн татвар		10,157,595.41	7,431,800.0	16,796,000.0	- 9,364,400.0	226.0
Даатгал		3,672,788.34	3,672,700.0	3,478,400.0	194,300.0	94.7
Аудит		1,300,000.00	1,300,000.0	1,300,000.0	-	100.0
Зохицуулах зөвлөл, тусгай зөвшөөрөл		7,910,860.00	6,881,300.0	6,881,300.0	-	100.0
Зар сурталчилгаа / хэвлэл мэдээлэл/		1,454,545.45	8,000,000.0	6,790,900.0	1,209,100.0	84.9
Зээлийн хүүгийн зардал		17,882,873.30	11,345,000.0	11,353,100.0	- 8,100.0	100.1
Төрөл бүрийн шимтгэл хураамж		27,231,859.80	3,000,000.0	3,461,600.0	- 461,600.0	115.4
Түрээсийн зардал		1,050,000.00	1,200,000.0	3,073,600.0	- 1,873,600.0	256.1
Гайхам GFS			1,716,000.0	748,800.0	967,200.0	43.6
ABLE программын зардал			60,000.0	789,000.0	- 729,000.0	1315.0
Алданги торгууль		24,600,000.00		6,871,300.0	- 6,871,300.0	
<b>Ашиглалтын зардал</b>		<b>293,870,488.42</b>	<b>398,760,800.0</b>	<b>640,274,100.0</b>	<b>- 141,513,300.0</b>	<b>135.5</b>
Эрчим хүч		138,378,749.83	192,307,300.0	158,072,000.0	34,235,300.0	82.2
Үндсэн хөрөнгийн элэгдэл		129,768,200.00	186,855,500.0	319,591,700.0	- 132,736,200.0	171.0
Харилцаа холбооны зардал		25,723,538.59	19,598,000.0	17,345,700.0	2,252,300.0	88.5
Үндсэн хөрөнгө акт алсны гарз				45,264,700.0	- 45,264,700.0	
<b>Сэлбэг хэрэгсэл, материал</b>		<b>268,473,161.94</b>	<b>280,780,200.0</b>	<b>263,377,070.1</b>	<b>27,403,129.9</b>	<b>90.2</b>
Түлш халаалтын зардал		144,776,234.29	121,981,100.0	132,953,470.1	- 10,972,370.1	109.0
Шатах тослох материал		55,867,085.96	44,029,200.0	42,200,800.0	1,828,400.0	95.8
Сэлбэг хэрэгсэл		22,349,793.76	40,922,200.0	39,318,300.0	1,602,900.0	96.1
Бичиг хэргийн зардал		8,007,428.15	24,086,500.0	11,410,800.0	12,675,700.0	47.4
Ариутгал цэвэрлэгээ, шинжилгээ		1,127,509.00	4,000,000.0	8,167,900.0	- 4,167,900.0	204.2
Хөдөлмөр хамгааллын зардал		26,345,110.78	41,148,800.0	15,110,600.0	26,038,200.0	36.7
Цэвэрлэгээний зардал			4,612,400.0	4,214,200.0	398,200.0	91.4
<b>Засвар үйлчилгээний зардал</b>		<b>153,750,262.95</b>	<b>130,613,400.0</b>	<b>114,049,400.0</b>	<b>16,564,000.0</b>	<b>87.3</b>
Засвар үйлчилгээний зардал		75,866,587.44	52,250,000.0	48,331,800.0	3,918,200.0	92.5
Гэрээт бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал			1,800,000.0	651,800.0	1,148,200.0	36.2
Үйл ажиллагааны бус зардал		77,881,675.51	46,692,600.0	52,805,500.0	- 6,112,900.0	113.1
Гамшигийн зардал			29,870,800.0	12,260,300.0	17,610,500.0	41.0
<b>нийт зардалын дүн</b>		<b>1,679,724,700.54</b>	<b>1,981,483,120.0</b>	<b>1,981,660,880.1</b>	<b>- 67,740.1</b>	<b>100.0</b>
Нийт ашиг, алдагдал		153,162,812.46	8,903,380.0	- 133,216,460.1	143,119,840.1	-1345.2
Орлогын татварын зардал		15,316,281.25	990,338.0			0.0
<b>Цэвэр ашиг</b>		<b>137,846,531.21</b>	<b>8,913,042.0</b>			<b>0.0</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Чандмань Баянхонгор” ХК-ны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирал М.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд орон нутгийн өмч, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн тайлагналын тухай болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-аас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд аудитор Б.Нарангэрэл хариуцаж хэрэгжүүлэв.

Чандмань Баянхонгор ХК нь 2020 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дугаар сарын 04 өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хувьцаат компани гэсэн статустай байна. Дүрэмд “нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3922938 ширхэг энгийн хувьцаатай байна. Хувьцааны 51 хувь буюу 2000698 ширхэг хувьцаа нь аймгийн ИТХ, 20 хувь буюу 784588 ширхэг хувьцааг ажилчдад эзэмшүүлж, 29 хувь буюу 1137652 ширхэг хувьцааг нээлттэй арилжина” гэж заасан байна.

Чандмань Баянхонгор ХК-ны дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийтийн аж ахуйн үйлчилгээ
- Хог хаягдал ялгах, зөөвөрлөх, боловсруулах үйлдвэрлэл, хот тохижилтын үйлчилгээ
- Суурин газрын ус хангамжийн худаг, ус түгээх цэгийн ашиглалт, засвар үйлчилгээ, зөөврийн ус хангамж
- 1000м3 хоног хүртэл хүчин чадалтай ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн заалтын дагуу Орон сууцны барилга, байгууламжийн цэвэр, бохир ус, дулаан, цахилгааны шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төвийн ашиглалт, засвар үйлчилгээ.
- Дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах
- Халуун хүйтэн усны тоолуур суурилуулах, худалдах
- Барилгын угсралт
- Мод ба өрөгт бүтээц барилгын ажил
- Барилын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна талбайн шугам сүлжээний угсралт
- Барилын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

- Ус хангамж ариутгах татуургын гол магистраль шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт зэрэг /Барилгын тухай хуулийн заалтын дагуу/
- Байгаль орчны нөхөн сэргээлт
- Компанийн хуулиар хориглоогүй бөгөөд орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аливаа бизнесийн бусад үйл ажиллагаа явуулж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана гэж тус тус заажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Чандмань Баянхонгор ХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2019 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас дотоод аудит, хяналт шалгалт хийсэн байна.

Санхүүгийн хяналт дотоод аудитын хяналт шалгалтаар нийт 6.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 6.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 20 заалт бүхий зөвлөмж өгч, хэрэгжилтийг 2020.07.25-ны дотор Санхүүгийн хяналт, аудитын албанд хүргүүлсэн байна.

Чандмань Баянхонгор ХК- ны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны 3 дугаар улирлын орлого үр дүнгийн тайлангийн нийт орлого 1286.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг тайлант оны 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн суурь үзүүлэлт болох нийт орлого 1848.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 18.5 сая төгрөгөөс тогтоолоо.

### **3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Чандмань Баянхонгор ХК-ны 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3656.8 сая төгрөгөөр буюу 109 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	140.43	11.55	- 128.88
Авлага	60.34	179.92	119.59
Урьдчилгаа	0.00	0.00	-
Бараа материал	115.30	130.66	15.37
Үндсэн хөрөнгө	3,037.22	6,687.97	3,650.75
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,353.28</b>	<b>7,010.11</b>	<b>3,656.83</b>
БХӨТ	309.7	183.3	- 126.4
УХӨТ	161.9	135.7	-26.2
Эздийн өмч	2,881.64	6,691.17	3,809.53
Төрийн өмч	313.8	313.8	
Хувийн өмч	78.5	78.5	
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,353.28</b>	<b>7,010.11</b>	<b>3,656.83</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 11.6 сая төгрөг болж 128.9 сая төгрөгөөр буурсан байгаа нь 2019 оны жилийн эцэст аймгийн Засаг даргатай 250,0 сая төгрөгийн өртөг бүхий Баянхонгор сумын 4,5 дугаар багийн дулааны шугамын ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулж, оны эцсээр тус гэрээний 50 хувь болох 125,0 сая төгрөгийн орлого орж ирсэн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өндөр гарах шалтгаан болжээ.

Авлага дансны үлдэгдэл 179,9 сая төгрөг болж 119.6 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын үед Монгол улсын засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаар тогтоолоор айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүртэл төрөөс хариуцан төлөхтэй холбоотойгоор үүссэн авлага, мөн өмнөх саруудын хэрэглээний төлбөрүүдийг төлөгдөөгүй үлдэгдэл зэргээс шалтгаалжээ. Мөн авлага дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн, он удаан жил болсон 33875.9 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Дээрх авлагыг Чандмань Баянхонгор ХК нь аймгийн ИТХ-д хүсэлт тавьсны дагуу 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдөр авлагыг данснаас хасах шийдвэр гаргасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 130.7 сая төгрөг болж 15.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны нүүрс худалдан авалт болон барилгын завсрын материал худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6666.0 сая төгрөг болж 3652.6 сая төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 48 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хонгор-1000 орон сууцны хорооллын 3712.4 сая төгрөгийн өртөг бүхий цэвэр усны шугам, дамжуулах төвийн барилга, Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар захирамжаар 19.9 сая төгрөгийн өртөг бүхий 3 зөөврийн ус түгээх байгууламж, Баянхонгор сумын ИТХ-ны тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 09 тоот тогтоолоор 59.8 сая төгрөгийн хөрөнгө, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын албан шаардлагаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 61.2 сая төгрөгийн хөрөнгө, мөн иргэнээс 26.5 сая төгрөгийн автомашин хандиваар авч, компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 101.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгөөс Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 102 дугаар тогтоолоор 51 нэрийн 171.1 сая төгрөгийн хөрөнгийг актлах шийдвэр гарсны дагуу акталж, данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө 433.5 сая төгрөг болж 3.0 сая төгрөгөөр өссөн нь Баянхонгор Чандмань ХК-ны ТУЗ-ийн 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоолоор маргаантай газрын эзэмшигчийг тогтоож, тус газрыг худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 318.9 сая төгрөг болж 152.7 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд 4,5 дугаар багийн шугамын ажлын гэрээний урьдчилгаа төлбөр болох 125.0 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэж байсан ч уг ажлыг гүйцэтгэх боломжгүй болсон тул аймгийн ЗДТГ-ын 2020.09.14-ны өдрийн 5/1258 тоот албан бичгээр гэрээг цуцалж, санхүүжилтийг буцаан төлүүлэх болсон тул дансны өглөгөөр бүртгэж, аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 80.0 сая төгрөгийг буцаан төлсөн. Мөн Баянговь сумын цэвэр усны хангамжийн ажлыг гүйцэтгэсэн учир урьдчилж төлсөн орлого дансанд бүртгэсэн 35.0 сая төгрөгийг үйл ажиллагааны бус орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн зэргээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 135.7 сая төгрөг байгаа ба энэ нь Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээл 84.4 сая төгрөг, Хас банкнаас авсан зээлийн үлдэгдэл 51.3 сая төгрөг байна. Урт хугацаат зээлийн үлдэгдэл 135.7 сая төгрөг болж 26.2 сая төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээлийн төлбөрт 5.0 сая төгрөг, мөн тус компанийн арилжааны банкнаас авсан зээлийн төлбөрийг 21.2 сая төгрөгийг төлснөөс шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 6691.2 сая төгрөг болж 3809.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хонгор-1000 орон сууцны хорооллын цэвэр бохир усны шугам, дамжуулах байр зэргийг үндсэн хөрөнгөд бүртгэснээс шалтгаалжээ. Үүнд:

- Орон нутгийн өмчийн дансны үлдэгдэл 4813.0 сая төгрөг болж 3855.8 сая төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 48 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хонгор-1000 орон сууцны хорооллын 3712.4 сая төгрөгийн өртөг бүхий цэвэр усны шугам, дамжуулах төвийн барилга, Баянхонгор сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар захирамжаар 19.9 сая төгрөгийн өртөг бүхий 3 зөөврийн ус түгээх байгууламж, Баянхонгор сумын ИТХ-ны тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 09 тоот тогтоолоор 59.8 сая төгрөгийн хөрөнгө, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын албан шаардлагаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 61.2 сая төгрөгийн хөрөнгө орлого авснаас шалтгаалсан байна.

- Хандивын капитал дансны үлдэгдэл 71.5 сая төгрөг болж 26.5 сая төгрөгөөр өссөн нь иргэнээс хандиваар авсан суудлын автомашиныг үндсэн хөрөнгөд бүртгэснээс шалтгаалсан байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 375.1 сая төгрөг болж 107.5 сая төгрөгөөр буурсан нь 3650.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр бүртгэсэн бөгөөд тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

### **3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн анхдугаар хуралдаанаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1991.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 1981.5 сая төгрөгөөр, ашгийг 8913.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 285.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1848.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1981.6 сая төгрөгийн зардал гарган, 133.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 1741.8 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 106.5 сая төгрөгийн орлого бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/ төгрөг/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Цэвэр усан хангамж	мян.төг	565,207,140.0	572,009,500.0	595,073,500.0	- 23,064,000.0	104.0
УТБ	мян.төг	80,216,982.0	77,942,700.0	101,133,500.0	- 23,190,800.0	129.8
Ариутгах татуурга	мян.төг	343,025,813.0	347,700,600.0	361,854,600.0	- 14,154,000.0	104.1
Суурь хураамж	мян.төг	93,391,881.0	93,391,900.0	102,125,400.0	- 8,733,500.0	109.4
Дулаан хангамж	мян.төг	570,423,761.0	600,341,800.0	581,639,800.0	18,702,000.0	96.9
Бусад орлого	мян.төг	180,621,935.0	300,000,000.0	106,507,600.0	193,492,400.0	35.5
<b>Нийт орлого</b>	мян.төг	<b>1,832,887,512.0</b>	<b>1,991,388,500.0</b>	<b>1,848,334,400.0</b>	<b>11,082,900.0</b>	<b>55.7</b>
Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	1,695,840,494.6	1,691,386,500.0	1,741,826,800.0	- 50,440,300.0	
<b>Нийт зардал</b>	мян.төг	<b>1,695,040,981.79</b>	<b>1,981,483,120.00</b>	<b>1,981,550,860.11</b>	<b>- 67,740.1</b>	<b>100.0</b>
Үүнээс:						
а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	1,545,884,072.80	1,839,828,720.00	1,896,225,860.11	(56,397,140.11)	103.07
б) Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	73,288,321.55	89,404,400.00	36,993,200.00	52,411,200.00	41.38
в) Хөрөнгө оруулалт их засвар	мян.төг	75,868,587.44	52,250,000.00	48,331,800.00	3,918,200.00	92.50
<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	мян.төг	<b>137,846,531.21</b>	<b>9,903,380.00</b>	<b>(133,216,460.11)</b>	<b>143,119,840.11</b>	

Нийт орлогын гүйцэтгэл 1848.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 143.0 сая төгрөг буюу 7.7 хувиар тасарсан нь Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 5 дугаар тогтоолоор дулааны үнэ тарифыг 1620 төгрөгөөр тогтоосон ч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аймгийн Засаг даргын шийдвэрээр хуучин үнэ тариф буюу 1500 төгрөгөөр тооцсоноос орлого тасрахад голлон нөлөөлсөн байна.

Мөн Ковид-19 цар тахалтай холбоотойгоор цэцэрлэг, сургуулиудын үйл ажиллагаа зогссоноос шалтгаалж 5 дугаар сард халаалтын төлбөр аваагүйн улмаар орлого тасрах шалтгаан болсон байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1981.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 0.06 сая төгрөг буюу 0.003 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг элэгдлийн зардлаар өссөн ч зарим үндсэн үйл ажиллагааны зардал хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 62 нэр төрлийн ажилд улсын төсвөөс 3,792.3 сая, төсөл хөтөлбөрөөс 62 сая, өөрийн эх үүсвэрээс 101.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 133.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 142.1 сая төгрөгөөр илүү байгаа нь орлого 7.2 хувиар дутуу биелсэн, зардал 0.003 хувиар хасагдсанаас тус тус шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 1, яам 1, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 3, хараат бус гишүүн 2, нийт 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 6 удаа зохион байгуулж асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 19.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 13.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 13.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 3: Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа нь болоогүй мэдээлэл	Байршуул аагүй
1	Бүтэн жил	4	4	2	2		
2	Хагас жил						
3	Улирал бүр						
4	Сар бүр	2	24	16	8		
5	Тухай бүр	6	72	60	12		
6	Нийт	12	100	78	22	0	0

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 100 мэдээллээс хугацаанд нь мэдээлсэн 78, хугацаа хоцроож мэдээлсэн 302.0 сая төгрөгийн 22 мэдээллийг байна. Үүнд: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1, Хөрөнгийн зардал, хөрөнгө

орруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 4, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 2, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 3, тушаал шийдвэртэй холбоотой 4, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 2, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 4, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 1 мэдээллийг тус тус хоцроосон байна.

### Санхүүгийн тайлангийн шинжилгээ:

Чандмань Баянхонгор ХК-ны 2020 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийхэд дараах харьцаанууд зохисгүй буюу анхаарал татахуйц байна. Үүнд:

1. Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөө ашиглан төлөх чадвар ямар байгааг илэрхийлдэг бөгөөд эргэлтийн харьцаа өндөр гарах тусам компанийн төлбөрийн чадвар сайн байгааг илэрхийлдэг бөгөөд 2-3 хооронд байхад зохистой гэж үздэг ч Чандмань Баянхонгор ХК-ны хувьд 1.8 байгаа нь авлагын эргэцийг түргэсгэж дансны авлагыг бууруулж бэлэн мөнгөний эргэлтийг сайжруулж, шаардлагатай байна.
2. Нийт хөрөнгийн эргэц нь байгууллага борлуулалтын орлого олохдоо хөрөнгөө хэр үр ашигтай ашиглаж байгааг харуулдаг бөгөөд нийт хөрөнгийн эргэц 0.5-с их буюу өндөр байх нь хөрөнгийн нөөц оновчтой, хөрвөх чадвар сайн байгааг илэрхийлдэг ч Чандмань Баянхонгор ХК-ны хувьд 0.25 буюу муу үзүүлэлттэй гарч байгаа нь компанийн эргэц муу, ашиглагдахгүй хөрөнгө их байгааг харуулж байна. Иймээс авлагын эргэцийг түргэсгэх, ашиглалтгүй бараа материалын эргэцийг сайжруулах шаардлагатай байна.

3. Бизнесийн гол зорилго бол ашиг олох явдал бөгөөд оруулсан хөрөнгийг илүү үр бүтээлтэй ашиглаж, орлогоороо зардлаа нөхөөд ашигтай ажилласан нөхцөлд үйл ажиллагаагаа өргөтгөх боломжтой болно. Ашигт ажиллагааны шинжилгээ нь оруулсан хөрөнгийн нэгж тутмаас олсон ашгийн хэмжээг мөнгөөр илэрхийлдэг чухал үзүүлэлт бөгөөд эдийн засгийн утга нь 40%-аас их байвал сайн ч Чандмань Баянхонгор ХК-ны хувьд -1.7 хувь буюу алдагдалтай гарч байгаа бөгөөд борлуулсан барааны өртөг нь борлуулалтын үнээсээ их гарч байна. Иймээс цаашид тэвчиж болох зардлуудыг хэмнэх шаардлагатайг харуулж, компанийн ашигт ажиллагааны түвшнийг сайжруулах шаардлагатай байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна. Өмнөх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 91 тоот албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

сая.төгрөг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	5.9	1	5.9	100%
Албан шаардлага					100%
Зөвлөмж	6	233.1	6	233.1	100%
Нийт дүн	7	239.0	7	239.0	100%

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 190.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.7 сая төгрөгийн алдааг залруулж, 45.0 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 12.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 129.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант хугацааны НӨАТ-ын тайланг тулгахад санхүүгийн тайланд 116.8 сая төгрөгийн НӨАТ-ын өглөгтэй байхад аудитаар 120.5 сая төгрөг буюу 3.7 сая төгрөгийн өглегийг дутуу тусгасныг санхүүгийн тайланд залруулав.

#### Төлбөрийн акт, албан шаардлага

1. Баянхонгор сумын 5 дугаар багт хийгдэх төвлөрсөн дулаан, ус хангамжийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэхээр Баянхонгор аймгийн Засаг даргатай 2019.12.24-нд гэрээ байгуулж, гэрээний санхүүжилтийн урьдчилгаа төлбөр болох 125.0 сая төгрөгийг хүлээн авсан байна. Чандмань Баянхонгор ХК нь төсөв өртөг нь хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар уг ажлыг гүйцэтгээгүй тул аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс Баянхонгор аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 125,0 сая төгрөгийг 2020.09.25-ны дотор буцаан төлөхийг шаардсан байхад 45.0 сая төгрөгийг төлөөгүй байна. байгаа нь Баянхонгор аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.1 дэх заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гэрээний урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл болох 45.0 сая төгрөгийг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс руу буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын 2020 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний зардлын төлөвлөгөөг тулгахад гадаад, дотоод аялалд 11.6 сая төгрөгийг төлөвлөж, 12.2 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 “Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд заасны дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байж, гадаад дотоод аяллын зардлыг бизнес төлөвлөгөөнд тусгаж, батлахгүй байх албан шаардлагыг Чандмань Баянхонгор ХК-ны ТУЗ-д хүргүүлэв.

### **3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Байхгүй

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Балансын данстай холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** 2020 оны санхүүгийн тайланд 318941.0 мянган төгрөгийн нийт өр төлбөр байгаа бөгөөд тайлант хугацааны БХӨТ -ийн дүн өмнөх оноос 126467.4 мянга буюу 69.0 хувиар буурсан ч нийт өр төлбөрт эзлэх хувийн жин 57.4 хувьтай байна. Үүнийг 120493.3 мянган төгрөг нь нэмэгдсэн өртгийн албан татварын өр төлбөр байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 “Тухайн сард борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг албан татвар суутган төлөгч төсөвт төлнө”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. **Эрсдэл:** Хууль тогтоомж хэрэгжихгүй байх.

1.3. **Өгсөн зөвлөмж:** Цаашид Төсвийн тухай хуульд заасны дагуу үйл ажиллагааны зардлаас зориулалт бусаар өр авлага үүсгэхгүй, мөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан хугацаанд өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр зөвшөөрсөн болно.

### **2. Балансын данстай холбоотой асуудал**

2.1. **Илрүүлэлт:** Тайлант хугацааны бараа материалын тайланг, нярвын тайлан, тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад нийт 0.8 сая төгрөгийн бараа материалын өртгийн зөрүү, мөн тооллогын комисс нь 8.0 сая төгрөгийн бараа материалыг тоолсон боловч орхигдуулж бүртгэлийг хөтөлсөн байгаа нь санхүүгийн тайлагналын “Үнэн ба зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2. Эрсдэл:** Холбогдох хууль, тогтоомж, заавар журам, стандартыг мөрдөөгүйгээс хөрөнгө дутагдах.

**2.3. Өгсөн зөвлөмж:** Байгууллагын жилийн эцсийн тооллого, тооцоог үнэн бодитой, чанартай гүйцэтгэх, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хариуцлагыг дээшлүүлж, санхүүгийн программ хангамжийн сайжруулалтыг хангаж ажиллах.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3. Удирдлагын дээд болон дотоод хяналт**

**3.1. Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 100 мэдээллээс хугацаанд нь мэдээлсэн 78, хугацаа хоцроож мэдээлсэн 302.0 сая төгрөгийн 22 мэдээлэл байгаа нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

**3.2. Эрсдэл:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

**3.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.8 “Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу батлагдсан төсөв гүйцэтгэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **4. Удирдлагын дээд болон дотоод хяналт**

**4.1. Илрүүлэлт:** Компанийн 2020 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийж үзэхэд эргэлтийн харьцаа 1.8 буюу зохистой түвшнээс доогуур, нийт хөрөнгийн эргэц 0.25 буюу зохистой түвшнээс доогуур, ашигт ажиллагааны түвшин -1.7 буюу зохистой түвшнээс хэт доогуур байна.

**4.2. Эрсдэл:** Компани төлбөрийн чадваргүй болох, дампуурах эрсдэлтэй.

**4.3. Өгсөн зөвлөмж:** Цаашид авлагын эргэцийг түргэсгэж дансны авлагыг бууруулж бэлэн мөнгөний эргэлтийг сайжруулж, ашиглалтгүй бараа материалын эргэцийг сайжруулж, тэвчиж болох зардлуудыг хэмнэх замаар компанийн ашигт ажиллагааны түвшнийг сайжруулах шаардлагатай байна

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.НАРАНГЭРЭЛ

ОГНОО: 2021.03.15

А.ЦЭЭНЯМ

ОГНОО: 2021.03.15

Б.МӨНХБАТ

ОГНОО: 2021.03.15

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр	Чандмань Баянхонгор ХК-ны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код
2020			БНА-2021/2/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр	Чандмань Баянхонгор ХК		Салбарын

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Чандмань Баянхонгор ХК нь төсөв өртөг нь хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар Баянхонгор сумын 5 дугаар багт хийгдэх төвлөрсөн дулаан, ус хангамжийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгээгүй тул аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс Баянхонгор аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 125.0 сая төгрөгийг 2020.09.25-ны дотор буцаан төлөхийг шаардсан байхад 45.0 сая төгрөгийг төлөөгүй байна.	45.0	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч	М.Мөнхбат, Б.Наранцэцэг
2	Байгууллагын 2020 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний зардлын төлөвлөгөөг тулгахад гадаад, дотоод аялалд 11.6 сая төгрөгийг төлөвлөж, 12.2 сая төгрөгийг Ковид-19 цар тахлын үед олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд зарцуулсан байна.	12.3	Албан шаардлага	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Б.Батбаяр
3	2020 оны санхүүгийн тайланд 318941.0 мянган төгрөгийн нийт өр төлбөр байгаа бөгөөд тайлант хугацааны БХӨТ-ийн дүн өмнөх оноос 126467.4 мянга буюу 69.0 хувиар буурсан ч нийт өр төлбөрт эзлэх хувийн жин 57.4 хувьтай байна. Үүний 120493.3 мянган төгрөг нь нэмэгдсэн өртгийн албан татварын өр төлбөр байна.	120.4	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч	М.Мөнхбат, Б.Наранцэцэг
4	Тайлант хугацааны бараа материалын тайланг, нярвын тайлан, тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад нийт 801.7 мянган төгрөгийн бараа материалын өртгийн зөрүү, мөн т19ооллогын комисс нь 8041.2 мянган төгрөгийн бараа материалыг тоолсон боловч орхигдуулж бүртгэлийг хөтөлсөн байна.	8.8	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч	М.Мөнхбат, Б.Наранцэцэг
5	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 100 мэдээллээс хугацаанд нь мэдээлсэн 78, хугацаа хоцроож мэдээлсэн 302.0 сая т190өгрөгийн 22 мэдээлэл байгаа	0	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч	М.Мөнхбат, Б.Наранцэцэг
6	Компаний 2020 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийж үзэхэд эргэлтийн харьцаа 1.8 буюу зохистой түвшнээс доогуур, нийт хөрөнгийн эргэц 0.25 буюу зохистой түвшнээс доогуур, ашигт ажиллагааны түвшин -1.7 буюу зохистой түвшнээс хэт доогуур байна.	0	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч	М.Мөнхбат, Б.Наранцэцэг

7	Тайлант хугацааны НӨАТ-ын тайланг тулгахад санхүүгийн тайланд 116.8 сая төгрөгийн НӨАТ-ын өглөгтэй байхад аудитаар 120.5 сая төгрөг буюу 3.7 сая төгрөгийн өглөгийг дутуу тусгасныг санхүүгийн тайланд залруулав. 3665.8	3.7	Санхүүгийн тайланд залруулав.	Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч	М.Мөнхбат, Б.Наранцэц эг
<b>ДҮН</b>		<b>190.2</b>			